



**ҮНДЭСНИЙ  
ХУВЬЧЛАЛЫН  
САН**

**2023**

**ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

## ТАНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ГҮЙЦЭТГЭЛ

- Үндэсний Хувьчлалын Сан хамтын ХОС (MSE:ХОС) нь 2020 оны 10 дугаар сард үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 2 жил 8 сарын хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд сангийн цэвэр хөрөнгийн дүн ₮5 тэрбумаас ₮6.5 тэрбумд хүрч чамлахааргүй өсөлтийг үзүүлжээ. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нэгж эрхэд ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ ₮129.17 хүрч, оны эхнээс 8.4% буурсан байна. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 29.2%-иар өсөөд байна.
- Үндэсний Хувьчлалын Сангийн багцын 79%-ийг дотоодын хувьцаа бүрдүүлдэг. Энэ нь сангийн цэвэр хөрөнгийн үнэлгээ буурахад голлон нөлөөлсөн үзүүлэлт боллоо. Сан нь хамгийн сайн үзүүлэлттэй урт хугацаанд үнэ цэнээ хадгална гэж тооцоолсон компаниудаар өөрийн хувьцааны багцаа бүрдүүлсэн ба хөрөнгийн зах зээлийн тэр дундаа хувьцааны үнэ ханшийн богино хугацааны савлагаанд өндөр ач холбогдол өгөлгүй, дунд болон урт хугацааны хөрөнгө оруулалтууд дээр төвлөрч багцаа бүрдүүлсэн тул энэхүү уналтаас санаа зовох зүйлгүй гэдгийг мэдэгдэх нь зүйтэй байх.
- ХОС нь Growth at a reasonable price (GARP) буюу өсөлттэй хувьцааг боломжийн үнээр худалдан авах хөрөнгө оруулалтын стратеги ашиглан хөрөнгө оруулалт хийдэг.



Хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн өгөөжийн харьцуулалт

	2020	2021	2022	2023Q2
Үндэсний Хувьчлалын Сангийн өгөөж	25.6%	91.2%	-24.4%	-8.4%
ТОП-20-ийн өгөөж	-1.7%	130%	-15.4%	-1.0%
Хадгаламжийн хүү	11.3%	~9%	10.3%	12%

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж, Монголбанк

## ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САНГИЙН ТОВЧ ГҮЙЦЭТГЭЛ

Тикэр  
**ХОС**

Гаргасан нэгж эрх  
**50 сая ширхэг**

Нэгж эрх эзэмшигчийн тоо  
**6,142**

Нэгж эрхийн хаалтын ханш  
**₮103.41**

Зах зээлийн үнэлгээ  
**₮5.17 тэрбум**

Хагас жилийн арилжааны эргэлт  
**₮221.9 сая**

Нэгж эрхийн NAV  
**₮129.17**

Нийт цэвэр хөрөнгө NAV  
**₮6.5 тэрбум**

## ТУЗ ГИШҮҮДИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



Галбадрахын Цогбадрах

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн  
ТУЗ-ийн дарга**

**Мэргэжил:** Эдийн засагч, санхүүч

**Албан тушаал:** “Ард Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн  
гишүүн, Гүйцэтгэх захирал, “Ард Менежмент ҮЦК”  
ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Батбилэгийн Золбоо

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн  
ТУЗ-ийн ердийн гишүүн**

**Мэргэжил:** Санхүү, эдийн засаг

**Албан тушаал:** “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн  
Гүйцэтгэх Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч,  
“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн ТУЗ-ийн дарга



Чулуунбаатарын Хандаа

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн  
ТУЗ-ийн ердийн гишүүн**

**Мэргэжил:** Эдийн засагч

**Албан тушаал:** “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал



Пүрэвийн Баянсан

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” ХХК-ийн ТУЗ-  
ийн хараат бус гишүүн**

**Мэргэжил:** Бизнесийн удирдлага

**Албан тушаал:** ХҮИС-ийн НББ, Санхүүгийн тэнхим  
ахлах багш



**Баяраагийн Баасандорж**

**“ҮНДЭСНИЙ ХУВЬЧЛАЛЫН САН” хамтын ХОС-ийн  
ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Мэргэжил:** Эрх зүйч

**Албан тушаал:** “Батбаяр Энд Партнэрс” ХХН-д  
өмгөөлөгч, МУИС, Санхүү, татварын эрх зүйн багш

“Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн баг “Үндэсний Хувьчлалын Сан” хамтын ХОС-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах зэрэг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлж ажилладаг.



**Чадраабал Даваасамбуу**

**Мэргэжил:** Санхүү, Хөрөнгө оруулалт

**Албан тушаал:** “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн  
сангийн менежер

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО

Сан нь хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тооцоо судалгаа хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийдэг бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны шинэчилсэн журмын дагуу Сангийн нийт хөрөнгийн 80-аас доошгүй хувиар дотоод болон гадаадын хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй хувьцаат компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж ажилладаг. Ингэхдээ компанийн суурь шинжилгээ, зах зээлийн судалгаа зэргийг багтаасан мэргэжлийн судалгаа шинжилгээнд үндэслэн хөрөнгө оруулалт хийдэг болно.


## НЭГЖ ЭРХ ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

2022 оны эцэст Үндэсний Хувьчлалын Сангийн нэгж эрх эзэмшигчдийн тоо 6,127 байсан бол 2023 оны эхний хагас жилийн байдлаар 6,142-д хүрсэн байна. Нэгж эрх эзэмшигчдийн тоо өмнөх жилийнхтэй ойролцоо түвшинд байгааг харвал сангийн үйл ажиллагаа хэвийн байгаа болон хөрөнгө оруулалтын сангийн эрэлт хэрэгцээ буураагүй байгаа зэргийг харж болж байна.

Нэгж эрх эзэмшигч	Нэгж эрхийн тоо	Хувь
АРД ДААТГАЛ	5,658,294	11.3%
ТУЛГА	3,000,000	6.0%
М СИ ЭС ИНВЕСТМЕНТ	2,500,000	5.0%
АРД МЕНЕЖМЕНТ ҮЦК	2,500,000	5.0%
АРД КРЕДИТ ББСБ	1,558,998	3.1%
БОГД БАНК	1,371,500	2.7%
АРДЫН ТЭТГЭВРИЙН ДАНС	1,116,155	2.2%
МАНДАХБАЯР	1,000,000	2.0%
НАРАНБАТ	1,000,000	2.0%
ЦЭРЭНДОЛГОР	807,141	1.6%
Бусад (6,132)	29,487,912	59.0%
<b>Нийт</b>	<b>50,000,000</b>	<b>100%</b>

## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛ


Цэвэр хөрөнгийн үнэлгээ 2023 оны эхний хагас жилд 6.5 тэрбум төгрөгт хүрч 8.4%-иар, зах зээлийн үнэлгээ нь 5.17 тэрбум төгрөгт хүрч 8.15%-иар тус тус буурчээ. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш цэвэр хөрөнгийн үнэлгээ 29.17%-иар өсөөд байна.



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж


	Зах зээлийн ханш	NAV(Цэвэр хөрөнгийн үнэ)
6/30/2023	103.41	129.17
Оны эхнээс %	-8.15%	-8.4%
Сан нээгдсэнээс хойш	+3.14%	+29.2%
2022 оны дээд доод	97.15 - 120.94	116.55 - 141

## Тайлант хугацааны туршид сангийн хөрөнгийн бүтцийн өөрчлөлт



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Тайлант хугацааны эцэс дэх сангийн хөрөнгийн задаргаа (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар)



Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК


ХОС-ын хувьд хөрөнгө оруулалтын бодлого болон зохицуулагч байгууллагын тогтоосон харьцаа үзүүлэлтийг өртгийн аргаар тооцсон хувь хэмжээгээр тооцдог бөгөөд харьцаа үзүүлэлтийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно. Багцын дахин тэнцвэржүүлэлтийг богино хугацааны давтамжтай хийх нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегитай харшилддаг тул бид өртгийн аргаар тооцож харьцаа үзүүлэлтийг хангаж ажилладаг билээ. Шалтгаан нь бид багцад байгаа өсөлттэй хувьцааны хувийн жинг бууруулахгүй байх, уналттай хувьцааны хувийн жинг өсгөхгүй байх нь хөрөнгө оруулалтын зөв бодлого гэж үздэгт оршино.

ХОС нь Монголын Хөрөнгийн Бирж дээрх нээлттэй компанийн хувьцаад түлхүү хөрөнгө оруулалт хийдэг ба багцын дийлэнх буюу 79 хувийг дангаар бүрдүүлж байна. Тайлант хугацаанд гадаад дотоодын нөхцөл байдлаас шалтгаалан дотоод болон гадаадын тодорхой хувьцаануудаа зарж гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой хувьцаануудаар багцаа сэлгэн хөрөнгө оруулалтууд хийсэн. Мөн тогтмол өгөөжтэй хөрөнгө оруулалтын хэрэгсэл багцдаа нэмж багцын 16 орчим хувьд хүргэсэн.



Эдийн засгийн нэг дэд салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ сангийн хөрөнгийн 25%-с хэтрэхгүй байхаар журамлагдсан бөгөөд дээр дурдсанчлан тооцоход харьцаа үзүүлэлтийг хангаж байна. 2023 оны 06 дугаар сарын 30-ний байдлаар ХОС-ийн хувьцааны багцад нийт 28 хувьцаа байгаа бөгөөд үүнээс 23 нь дотоодын хувьцаа, 5 нь гадаад хувьцаа байна.

**Хувьцааны багц, эдийн засгийн дэд салбараар** (Зах зээлийн үнэлгээгээр болон өртгийн аргаар, нийт хөрөнгийн багцад эзлэх хэмжээ %)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

## САНГИЙН ЗАРДАЛ

Тайлан хугацаанд сангийн нийт хөрөнгийн өдрийн дундаж үлдэгдэл нь 6,266.3 сая төгрөг байсан бөгөөд зардлын нийт дүн нь 155 сая төгрөг болсон байна. Нийт хөрөнгийн дундаж үлдэгдлээс тооцсон нийт зардлын харьцаа нь 2023 онд 2.4% байна.

### Зардлын задаргаа(Сая төгрөгөөр)




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

## САНГИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тайлант хугацааны эцэст зах зээлийн үнэлгээгээр тооцвол багцын 83%-ийг эрсдэл өндөртэй хөрөнгө буюу хувьцаа эзэлж байгаа бол үлдсэн хэмжээг эрсдэл бага, тогтмол өгөөж бүхий хөрөнгүүд эзэлж байна.

Сангийн өдөр бүрийн цэвэр хөрөнгийн үнэлгээний (NAV) тоо мэдээнд тулгуурлан шинжилж үзвэл, эрсдэлийн үзүүлэлтүүд нь дараах байдалтай байна.

### Өдрийн NAV хөдөлгөөний тархалт




Эх сурвалж: Ард менежмент ҮЦК ХХК

Нийт ажиглалтын тоо 245 бөгөөд өдрийн стандарт хазайлт нь 1.35% буюу жилийн 21.34% болно. Эрсдэлгүй хүүг Монголбанкны бодлогын хүү болох 13%-р тооцвол, Sharpe ratio (эрсдэлээр жигнэсэн өгөөжийг илтгэдэг харьцаа) нь 1.76 гарч байна.

## НЭГЖ ЭРХИЙН АРИЛЖАА

Үндэсний Хувьчлалын Сан нь хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сан буюу гаргасан нэгж эрхээ эргүүлэн худалдан авах үүрэг хүлээдэггүй сан юм. Хөрөнгө оруулагчид нэгж эрхээ Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан өөр хоорондоо арилжаалах боломжтой байдаг бөгөөд сангийн хөрвөх чадвар сайн байх нь зах зээлийн ханш зөв тогтох үндэс болдог. ХОС-ын нэгж эрхийн арилжааны эргэлт 2023 оны эхний хагас жилд ₮221.9 сая байгаа ба нийт 5.1 сая ширхэг нэгж эрх арилжаалагдсан ба энэ нь сангийн 4.2 хувь гар сэлгэсэн байна.



## САНГИЙН МЕНЕЖЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Үндэсний Хувьчлалын Сангийн менежер Ч.Даваасамбуу нь хөрөнгө оруулалтын сантай холбоотой хууль, дүрэм, журмын хүрээнд сангийн хөрөнгийг удирдаж, өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан ажиллаа. ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтын стратегиар хөрөнгө оруулалтууд хийдэг ба 2023 онд Монголын хөрөнгийн зах зээл харьцангуй тогвортой буюу хэлбэлзэл багатай жил байсан ба цэвэр хөрөнгийн үнэлгээ оны эхнээс 8.4 хувиар буураад байгаа билээ. Харин үүсгэн байгуулагдсан цагаас хойш 29.2 хувийн өсөлттэй байна.

Сангийн менежерийн үндсэн ажлыг хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны гэж хоёр хувааж авч үзэж болох бөгөөд дараах ажлууд тогтмол болон тухай бүр хийгдсэн байна.

Сангийн хөрөнгийн удирдлагатай холбоотой ажлууд:

- Хөрөнгө оруулалтын багцыг удирдах. ХОС нь урт хугацааны хөрөнгө оруулалтууд хийдэг ба хэтэрхий өндөр үнэлэгдсэн тодорхой хэдэн хувьцаануудаас гарсан ба өсөлт үзүүлэх боломжтой дунд хугацааны хөрөнгө оруулалтууд хийж ажиллаа.
- Хөрөнгө оруулалтын судалгаа, шинжилгээг тогтмол хийж, хөрөнгө оруулалтын боломжийг эрэлхийлэх.
- Хөрөнгө оруулалтын нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж, сангийн менежерийн эрхийн хүрээнд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах, зөвшөөрөгдсөн хэмжээнээс өндөр дүнтэй хэлцлүүдийг ТУЗ-н шийдвэрээр гүйцэтгэх.

Сангийн үйл ажиллагаатай холбоотой ажлууд:

- Сангийн үнэ ханшийн мэдээллийг өдөр бүр олон нийтэд хүргэх.
- Улирал бүр ТУЗ-ийн хурлыг хуралдуулж сангийн үйл ажиллагаа, үр дүнг танилцуулах, шаардлагатай шийдвэрүүдийг гаргуулах.
- Улирал бүр Earning Call хийж сангийн үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд хүргэх.
- Зохицуулагч байгууллагуудтай харилцах.
- Кастодиан банкинд сангийн хөрөнгийг хадгалуулах, тайлан мэдээний үнэн зөв байдалд хяналт тавих.
- Сангийн хагас жилийн болон бүтэн жилийн тайланг бэлтгэж олон нийт болон зохицуулах байгууллагад хүргүүлэх.
- СЗХ-ны хяналт шалгалт болон хөндлөнгийн аудит хийлгэх, холбогдох материалыг бүрдүүлэх, үүрэг даалгаврыг биелүүлэх.

## 2023 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Дэлхийн гадаад харилцааны шинэ өөрчлөлтүүд болон өмнө нь үүссэн шийдэгдээгүй асуудлууд дэлхийн эдийн засагт тодорхой бус нөхцөл байдал үүсгээд байна. Цаашид Орос-Украины дайн үргэлжлэх хандлагатай байгаа нь төв банкуудыг мөнгөний хатуу бодлого үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээс өөр аргагүйд хүргээд байна. Үүний үр дүнд цаашид дэлхийн эдийн засгийн байдал тогтворгүй болох ба өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлт өнгөрсөн онд 2.7% байсан бол энэ онд 1.3 хувь болж буурна гэсэн таамаглалтай байна.

Харин зарим томоохон төв банкууд бодлогын хүүгээ нэмэгдүүлэхээ сааруулж байгаатай холбоотойгоор инфляцын эрч саарч цаашид хүлээлт тогтворжих магадлалтай. Мөн 2023 оны эхний улиралын байдлаар дэлхийн улс орнуудын ДНБ-ний өсөлтийн түвшин өмнөх оны үзүүлэлтээс өссөн байгаа нь ковидын дараах хямралаас эдийн засаг бага багаар сэргэж байгаагийн шинж юм. Мөн европын холбооны болон европын бусад орнуудын өсөлтийн хувь бага байгаа нь Орос-Украины дайнаас үүдэн бий болсон үр дүн юм.


ДНБ болон инфляцын жилийн өсөлтийн харьцуулалт(2022Q1, 2023Q1 он)

Эдийн засгийн үзүүлэлт	Улс	2022Q1	2023Q1	Зөрүү
ДНБ жилийн өсөлт	Монгол	4.7%	7.9%	0.7%
	АНУ	0.9%	1.6%	1.6%
	БНХАУ	2.9%	4.5%	-0.8%
	ЕХ	1.8%	1%	3.2%

Эх сурвалж: Блүүмбэрг

Он гарснаас хойш АНУ-ийн цахиурын хөндийн 3 банкны дампуурал,, АНУ-ийн Засгийн газрын өр дээд цэгтээ тулж деофолд зарлахад ойрхон байгаа мөн ХНС-аас 10 дахь удаагаа бодлогын хүүг өсгөсөн гэх зэрэг асуудлуудтай бид нүүр тулаад буй. Гэвч эдгээр асуудлуудыг үл харгалзан 2023 он гарснаас хойш дэлхийн зах зээл харьцангуй өсөлттэй байна. Үүнээс АНУ-ийн томоохон компаниудыг багцалсан индекс S&P500 3 сараас хойш 15%, Dow Jones 6.8%, NASDAQ 25.9%-ийн өсөлтүүдийг үзүүлсэн.

### Голлох хөрөнгийн захын индексийн жилийн өөрчлөлт




Эх сурвалж: Блүүмбэрг

S&P500 индекс нь 14% өсөлт буюу харьцангуй сайн өсөлттэй байгааг харж болно. Энэ өсөлтөнд хамгийн их нөлөөлсөн секторуудыг харвал хувийн жингээрээ хамгийн их буюу 27%-ийг эзэлдэг технологийн салбарын 35.9% өсөлт, харилцаа холбооны салбарын 35% өсөлтүүд юм. Үүнд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь технологийн салбарын Nvidia групп +181%, Apple компани+41.6%, Microsoft Corp-н +40% зэрэг өссөн хувьцааны ханшийн өсөлтүүд индексийн голлон нөлөөлөв.

Эх сурвалж: Блүүмбэрг

Монголбанкны зүгээс инфляцын түвшин бууруулах зорилгоор 2022 онд бодлогын хүүгээ 5 удаа нэмэгдүүлж 13%-д хүргээд байгаа ба 2023 онд 2 удаагийн хурлаар 13%-ийг хэвээр хадгалсаар байгаа билээ. Үр дүнд нь 2022 оны 6 сард 17%-д хүрээд байсан инфляцын түвшин 2023 оны 6 сарын байдлаар 10.6%-д хүрч буураад байна. Монголбанкны шинжээчдийн үзэж буйгаар бол 2024 оны нэгдүгээр улирал гэхэд инфляцыг зорилтот түвшин болох 6±2%-д хүрэх төсөөлөлтэй байгаа билээ.

### Монголбанкны бодлогын хүү болон инфляцын хамаарал



Эх сурвалж: Монгол Банк

Нөгөөтэйгүүр бодлогын хүү өндөр хэвээр байгаа нь банкуудийн хадгаламж болон засгийн газрын үнэт цаасны өгөөжийн хувь хэмжээг нэмэгдүүлэх суурь хүчин зүйл бөгөөд энэ нь нийт хадгаламжийн хэмжээг нэмэгдүүлж зах зээл дээрх мөнгөний эргэлтийг бууруулдаг. Мөн тогтмол төлбөр бүхий хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн нэрлэсэн өгөөжийг нэмэгдүүлсэнээр хөрөнгө оруулагчдыг хувьцааны заххаас илүү бонд, ХБҮЦ, ЗГҮЦ зэрэг хэрэгслүүд рүү хандуулж байгаа нь хөрөнгийн зах зээлийн өсөлтөнд саар болсоор байгаа билээ.

## САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Нийт хөрөнгийн хувьд 6,637 сая төгрөгийн хөрөнгөтэй, цэвэр хөрөнгө 6,458 сая төгрөгт хүрсэн бөгөөд 2022 оны эцэстэй харьцуулахад хөрөнгө 9.3%, цэвэр хөрөнгийн дүн 8.4%-ийн бууралтыг тус тус үзүүлсэн байна.

### САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2022 Q4	2023 Q2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,318</b>	<b>6,637</b>
Мөнгө	276	290
Санхүүгийн хөрөнгө /Бодит/	6,651	6,209
Санхүүгийн хөрөнгө /Хорогдуулсан.Ө/	372	55
Авлага	19	
<b>Нийт өр төлбөр</b>	<b>267</b>	<b>179</b>
Дансны өглөг	45	32
Орлогын татварын өр	7	7
Хойшлогдсон татварын өр	215	140
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>7,051</b>	<b>6,458</b>
Өмч	5,000	5,000
Хуримтлагдсан ашиг	2,051	1,458

### ОРЛОГЫН ТАЙЛАН

Сая төгрөг

Үзүүлэлт	2022 Q4	2023 Q2
Хүүгийн орлого	121	52
Ногдол ашгийн бодлого	106	26
Бодит үнэ цэнийн өсөлтийн олз	(2,640)	(673)
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(2,413)</b>	<b>(595)</b>
ХОМК-ийн үйлчилгээний зардал	(177)	(87)
Кастодианы үйлчилгээний зардал	(25)	(12)
Бусад зардал	(127)	(57)
<b>Нийт үйл ажиллагааны зардал</b>	<b>(329)</b>	<b>(155)</b>
Татварын өмнөх ашиг	(2,543)	(743)
Хойшлогдсон татварын зардал	268	(68)
<b>Тайлант үеийн цэвэр ашиг</b>	<b>(2,275)</b>	<b>(675)</b>